

Living the Lotus

Buddhism in Everyday Life

12
2021

VOL. 195

С Н А Н С Е

Үүсгэн байгуулагчийн бодрол

Итгэлийн хүч

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 195 (2021.12)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК,
Мөнхцэцэг
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон
улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-
international@kosei-kai.or.jp

Миний энэ жил хамгийн ихээр баярлаж хөөрсөн зүйл бол яахын аргагүй Дэлхийн шашинтнуудын энх тайвны 6-р чуулгын нээлтийн ёслолд оролцсон минь байлаа.

Ватикан дахь Дэлхийн хамба нарын чуулгын танхимд Ромын пап II Иохан Паулогоос авахуулаад бусад шашны төлөөлөгчид цуглан дэлхий дахинд тулгарч буй саад бэрхшээлийг хэрхэн даван туулах шийдлээ ярилцаж буйг хараад бие чичрэх шахам сэтгэл хөдөлж байснаа санаж байна.

Шинжлэх ухаан, урлаг соёл, тулааны урлаг, спорт гэх мэт ямар нэгэн зүйлээр дамжуулан аливаа зүйлийн гүн утга учрыг мэдэж, хүний мөн чанарыг ухан ойлговол ертөнцийн жинхэнэ үнэнийг ухаарна. Ингэснээр зөрүүд хатуу зан арилж, ямар ч хүн, ямар ч зүйлийг ойлгон хүлээж авч, үнэ цэнийг нь амилуулж чадах уужуу сэтгэл бий болдог.

Шашны зам мөр ч гэсэн мөн адил. Итгэж үнэмшиж буй сургаалынхаа гүнд нэвтэрч, мөн чанарыг нь ойлгосон цагт хүнд сэтгэлийнхээ гүнээс итгэдэг болж, ямар ч хүнтэй нэрэлхэж, санаа зовох зүйлгүй харилцаж чаддаг болно. Энэ итгэлийн хүчийг нэгтгэж чадвал бид 21-р зуунд дайн дажингүй, амгалан тайван дэлхийг бүтээж чадна. Үүний төлөө бүхий л хүчээ дайчлан зүтгэх хэрэгтэй юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X104-105

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Дотоод сэтгэлээ сонсохуй

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Наминчлал бол гэгээрэл

Цагаан Лянхуа судрын дүгнэлт судар болох Иж бүрний билигт бодьсадвагийн даяны бүтээл сударт “Энэ наминчлалаар явагч хүмүүн бие сэтгэл машид арилаад номын дотор үл суухуй нь даруй урсгал усны мэт болой.” хэмээх бадаг бий. Өөртөө дүгнэлт хийх, наминчлах үйлийг үргэлж санаж явах аваас амьдрал урсгал ус мэт эрх чөлөөтэй, өөдрөг тэнүүн болно гэсэн утгатай. Түүнчлэн дээдийн наминчлал бол “хамаг юмсын мөн чанарыг нарийн тунгаан бодох явдал” гэжээ. Хоосон бодол, шунал хүслээсээ ангижирч, аливаа зүйлийн жинхэнэ дүр төрхийг харах хэрэгтэй гэсэн үг юм. Энэ нь өөртөө дүгнэлт хийж, гэмээ ухааран наминчлахтай ямар холбоотой болох нь бага зэрэг ойлгомжгүй санагдаж магадгүй.

Үүнийг тайлбарлахын тулд байнга цүнхэндээ хийн авч явдаг, хэрэг болохоор гаргаж хардаг нэгэн “Түүхэн он тооллын товчоо”-ны талаар ярья. Тус номонд сансар огторгуй ба дэлхий, амьд организм ба хүн төрөлхтний үүсэл хөгжлийн түүхийн талаар хураангуйлсан байдаг. “Бидний одоо оршин буй газар ба ирээдүй” гэсэн гарчигтай тус номын эхэнд ингэж бичсэн байдаг:

“Дэлхий бол сансар огторгуйд үүсэн бий болсон олон мянган оддын нэг. Тэнд далай тэнгис бий болж, улмаар амьд биет үүсч олон төрөл зүйл болон салбарлан хувьсаж, хүн хэмээх бодгаль бий болсныг орчин цагийн шинжлэх ухаан нотолсон. Хүмүүс бидний амь нас сансар огторгуй, дэлхий, амьд организмын түүхтэй салшгүй холбоотой.”

Би энэ номыг харах болгондоо “хүн ийнхүү хувьсан хөгжсөөр энэ хүртэл ирсэн шүү дээ” хэмээн хүний оршихуй, амь насны гайхамшгийг биширдэг юм. Мөн бүхий л юмс үзэгдэл хязгааргүй цаг хугацаа, өөрчлөлт хувьслын явцад хамтдаа бүтээсэн нэгэн бүхэл агуу том ертөнц, агуу том түүхийн талаар бодно. Ялангуяа яахаа мэдэхгүй арга мухардсан үедээ ийнхүү бодох ахуйд “нээрэн би ч гэсэн дэлхий ертөнц, түүхийг бүтээгчдийн нэг шүү дээ” хэмээн харах өнцөг тэлж, сэтгэл санаа уужирдаг.

Бодитоор харах юм бол хүмүүс, юмс үзэгдэл харилцан адилгүй боловч нөгөө талаар туйлын үнэний өмнө ямар ч ялгал үгүй эрх тэгш мөн чанартай. Дээдийн наминчлал гэдэг нь энэхүү мөн чанарыг ухаарсны үндсэн дээр өөрийгөө эргэцүүлэн бодох явдал бөгөөд энэ нь бие сэтгэлийг ариусгах гэгээрлээс өөрцгүй гэж хүртэл бодогддог юм.

Цагаан лянхуа судар ба Косей Кай нийгэмлэгийн гол үзэл санаа

Би энэ хүртэл өөртөө дүгнэлт хийх болон наминчлах талаар нэгтгэн ярилаа. Шашин шүтлэгийн хүрээнд өөрийгөө олж харж наминчлах нь өөртөө дүгнэлт хийх талаарх нийтлэг ойлголтоос өөр гэж бодох хүн байж магадгүй. Мэдээж хэрэг шашин шүтлэгийн наминчлах үйлийн хувьд өөрийгөө ялан дийлж, тэсвэр тэвчээр гарган бурханы зам мөрийг хэрэгжүүлэн өсөн дэвшихийн төлөөх үйл гэсэн утга нь илүү хүчтэй байж магадгүй. Гэхдээ энгийн нийгэм дэх өөртөө дүгнэлт хийх гэсэн ухагдахуун ч гэсэн ялгаагүй өсөж хөгжих зорилгыг агуулдаг гэж бодож байна. Тиймээс миний хувьд өөртөө дүгнэлт хийх ба наминчлах үйл нь утга адилхан зүйл гэж ойлгодог.

Шашны наминчлах үйлийн талаар нэмж хэлэхэд сэтгэлд төрж буй өөрийгөө эргэцүүлэн бодох, гэмших мэдрэмжийг дотор орших бурханыхаа дохио гэж ойлгож болно. Сударт наминчлахыг хүсвээс “*Чи бээр магад Бурханд залбирваас зохимуй*” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл “уур хилэн, шунал хүслээ барьж чадахгүй байх үедээ өөрийн дотор орших Бурханаа сонс, жинхэнэ өөрийгөө ол” хэмээн ухааруулах дотоод Бурханыхаа дуу хоолойг чих тавин чагнах хэрэгтэй хэмээн сургажээ. Хааяа нэг өргөн уудам сансар огтогуйд хөвөн дүүлж, дэлхий, амьд биетийн үүсэл хөгжлийн түүхийн талаар эргэцүүлж, хүн төрөлхтөн ба би гэдэг оршихуйн мөн чанарын талаар тунгаан бодох. Ийнхүү дотор орших Бурхантайгаа нүүр тулж, дуу хоолойг нь сонсох аваас илүү утга учиртай амьдрах ухаан сууна. Дараа нь ухаарсан зүйлээ хэрэгжүүлэх л үлдэнэ.

Ничирэн гэгээнтэн “Хамгийн нандин судар бол Цагаан лянхуа судар, Цагаан лянхуа судрын хамгийн чухал сургаал бол Насад зэвүүцэхгүй бодисадвагийн үйл юм” хэмээн айлдсан. Лянхуан Гурамсан Сударыг гол сургаал номлолоо болгодог манай нийгэмлэгийн хувьд Үүсгэн байгуулагч бурханлаг чанарт мөргөн хүндэтгэх үйлийг чухалчлан манлайлан хэрэгжүүлдэг байсан нь Насад зэвүүцэхгүй бодисадвагийн биеэ авч явах байдал нь хүмүүсийн үлгэр дуурайл гэж үзсэн болохоор юм. Бурханлаг чанарт мөргөх үйлийг наминчлах үйлийг бодитоор хэрэгжүүлэх хамгийн ойрын жишээ гэж хэлж болно.

Үүсгэн байгуулагчийн өдөр бүр мөргөдөг байсан алга хамтатган залбирах бурханы дүр одоо ч манай гэрт хамаг амьтны аз жаргалын төлөө залбирсаар байгаа билээ.

«Косей» 12-р сарын дугаар

Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

Мёокоо багшантай учирсан нь

Үүсгэн байгуулагч Цагаан лянхуа судрыг түгээн дэлгэрүүлэхэд амар гэж үзэн сүүний мухлаг нээжээ.

Сүү хүргэж өгдөг газруудын нэг нь Мёокоо багштан (жинхэнэ нэр нь Наганума Маса, хожим Мёокоо болгож өөрчилсөн)-ы гэр байж. Тэрээр зундаа мөс, өвөлдөө чихэрлэг төмс зардаг байсан бөгөөд бие нь тийм ч сайнгүй байв.

Үүсгэн байгуулагч сүү хүргэхээр очихдоо өвчиндөө шаналж буй Мёокоо багшид өвөг дээдсийн номын утга учрыг тайлбарласнаар Мёокоо багштан бурханы сургаалтай учирсан гэдэг.

Хожим нь Үүсгэн байгуулагч түүнтэй хамтран Рисшо Косей Кай байгууллагыг үүсгэн байгуулж, олон түмэнд бурханы сургаал түгээн дэлгэрүүлэх болжээ.

1



2



3



5



4

Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагч өглөө оройдоо сүүгээ түгээчих юм бол үлдсэн цагтаа Цагаан лянхуа судрыг судалж, түгээн дэлгэрүүлж болох юм байна гэж үзэн даршилсан ногооны дэлгүүрээ болин сүүний мухлаг нээсэн юм.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Рисшо Косей Кай нийгэмлэгийг үүсгэн байгуулсан нь



Тус нийгэмлэг нь 1938 оны 3 сарын 5-нд үүсгэн байгуулагдсан юм. Тухайн үед “Дай Ниппон Рисшо Косей Кай” гэдэг нэртэй байсан бөгөөд 1960 онд одоогийн нэрээр өөрчлөгджээ.


Байгуулагдах үед нийгэмлэг 30-аад гишүүнтэй, төв нь сүүний мухлаг ажиллуулж байсан Үүсгэн байгуулагчийн гэрт байрладаг байв.

Үүсгэн байгуулагч үүрийн 4 цагаас эхлэн сүүгээ түгээн, өдрийн цагаар гишүүдийнхээрээ айлчлан сургаал түгээнэ. Тэгээд оройныхоо сүүг түгээчихээд тэдори хийн, зорьж ирсэн хүмүүстэй ярилцан өдөр бүрийг завгүй өнгөрөөдөг байжээ.



☀ Бяцхан мэдлэг

Рисшо Косей Кай-гэдэг нэрний Рисшо гэдэг нь бурханы зөв сургаалд тулгуурлах гэсэн утгатай. Косей гэдэг нь олон хүмүүсийн харилцаа холбоогоор дамжуулан бие биенээ урамшуулан дэмжиж, хүнлэг мөн чанарын оргилд хүрэх гэсэн утгатай юм.



Олон улсын хэлтсийн даргын булан

Наминчлах үйлийг хэрэгжүүлэх ойрын жишээ

Бид энэ сард ч бас Нивано ерөнхийлөгчөөс “Наминчлал”-ын талаарх айлдварыг үргэлжлүүлэн сонслоо. Талархан хүлээн авч хэрэгжүүлье гэж бодож байна.

Тэрээр айлдварын эхний хагаст гэм буруугаа ухааран наминчлахуйн талаар сургасан. Харин сүүлийн хагаст гэмээ ухаарч наминчлах үйлийг хэрэгжүүлэхэд ойрхон жишээ болгон Насад зэвүүцэхгүй бодьсадвагийн үйлийн талаар дурьдан бурханлаг чанарт мөргөх бодьсадвагийн үйлийг хэрэгжүүлэхийг уриалжээ.

Наминчлал гэдэг нь “Юмсын жинхэнэ дүр төрхийг гүн гүнзгий эргэцүүлэн тунгаах явдал”, өөрөөр хэлбэл хоосон бодол, шунал хүслээсээ ангижран аливаа зүйлийн мөн чанарыг олж харах явдал хэмээн айлдсан. Энэхүү мөн чанарыг харах гэдэг нь эгэл жирийн бидний хувьд сонсогдож байгаа шигээ хялбар зүйл биш.

Тиймээс Нивано ерөнхийлөгч байнга биедээ авч явдаг “Он цагийн товчоо”-ны талаарх номноосоо иш татан ертөнцийн үүслээс эхлээд дэлхий, хүн төрөлхтнийг багтаасан орчлон ертөнцийн агуу түүхийг өгүүлж, өөрийгөө түүний нэгэн хэсэг гэж хүлээн авснаар сэтгэл хөнгөрч, бие сэтгэл ариусдаг хэмээн өөрийнхөө туршлагаас хуваалцсан байна.


Тэгэхээр таны “дотор орших бурхан” юуг хүүрнэж байна вэ? Бурханлаг чанарт мөргөх үйлээр дамжуулан дотоод сэтгэлийнхээ дуу хоолойг чих тавин сонсоод үзээрэй.

Акагава Кэйичи



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
 URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkony39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dharma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dharma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanail, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>